


2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Хаврын улиралд цаг агаар тогтворгүй байдагтай холбоотой агаарын температурын хэлбэлзэл ихэсдэг. Манай орны 3 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар -12°C (10.4°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар -5°C (23°F) –аас $+3^{\circ}\text{C}$ (37.4°F), бусад нутгаар -6°C –аас -12°C (21.2°F –аас 10.4°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 3 дугаар сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 2 хувьтай тэнцдэг. Тус сард Булган, Хэнтийн зүүн хойд, Хангайн нурууны зүүн хэсгээр 5-10 мм, Өлгий, Ховд болон Увс, Говь-Алтайн баруун хэсэг, Дундговь, Дорноговь аймгийн нутгаар 0.2-2.0 мм бусад нутгаар 1.5-4 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 3 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2026 оны 3 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -0.6°C -аар хүйтэн, ОЖД-аас 1.3°C -аар дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 18 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 76% нь дунджаас $+1.1$ –ээс $+6.8^{\circ}\text{C}$ -аар дулаан, 20.9% нь дунджийн орчим, 3.1% нь дунджаас хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 1.6 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 73.2%-иар, ОЖД-аас 40.3%-иар бага бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 18 дахь хур тунадас багатай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн дийлэнх буюу 82.2% нь дунджаас бага, 10.1% нь дунджаас ахиу, 7.8% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2026 оны 3 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон Баруун, Төв, Өмнө, Зүүн бүсээр ангилан тооцоолсон 3 дугаар сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) нийт нутгаар 1 дүгээр арав хоногийн дунд хүртэл, мөн 2 дугаар арав хоногийн зарим хугацаанд ОЖД-аас -0.5 -аас -9.7°C -аар хүйтэн байсан байна. Харин сарын ихэнх хугацаанд бүх нутгаар ОЖД-аас $+0.6$ -аас $+10.6^{\circ}\text{C}$ -аар дулаан байжээ. Хур тунадасны хувьд ихэнх нутгаар 1 болон 2 дугаар арав хоногийн эхээр харьцангуй ахиу хур тунадас оржээ.



Зураг 3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Энэ сард температурын үнэмлэхүй бага утга Увс аймгийн Тэс суманд агаарт -40.5°C , хөрсөнд Увс аймгийн Баруунтуруун суманд -45°C хүрч хүйтэрсэн. Харин температурын үнэмлэхүй их утга Дорноговь аймгийн Замын-Үүд суманд агаарт 19.8°C , хөрсөнд Баянхонгор аймгийн Шинэжинст/Эхийнгол/ суманд 42°C хүрч ажиглагдсан байна. Хоногт хамгийн ихдээ Архангай аймгийн Төвшрүүлэх суманд 26-ны өдөр 6.6 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 959.9гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 764гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Ховд аймгийн Мөст суманд 26 м/с хүрчээ.



Зураг 4. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд